



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/107

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 45 дугаар зүйлийн 45.6, 45.7 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хавсралтаар баталж, 1-3, 4.1, 5-9 дэх заалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар (Д.Батцэцэг)-т, 4.2 дахь заалтын төсөл, арга хэмжээг цахим дэлгүүрээс худалдан авах ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар (П.Эрхэмбулган)-т тус тус шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

2.Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Эрдэнэбадрах)-т, 1, 2 дахь заалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Боловсролын газар (Б.Амартүвшин)-т, 3, 4.1, 4.2 дахь заалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар (П.Эрхэмбулган)-т, 5-7 дахь заалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т, 8 дахь заалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (Д.Мөнхбаатар)-т, 9 дэх заалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Хот байгуулалт, хотын стандартын газар (Г.Баярсайхан)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1725020507

Нийслэлийн Засаг даргын 2025 оны  
 07 дугаар сарын 30 ны өдрийн  
 А/107 дугаар захирамжийн  
 хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төгрөг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Боловсролын салбарын шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар хот)	2025	2025	1,000.0	1,000.0
2	Хүүхдийн хоол үйлдвэрлэлийн угаагч, ариутгагч тоног төхөөрөмж (Улаанбаатар хот)	2025	2025	6,796.0	6,796.0
3	Түргэн тусламжийн бүрэн тоноглогдсон автомашин (Улаанбаатар хот)	2025	2025	1,580.0	1,580.0
4	Эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар хот)			9,393.0	9,393.0
4.1	Эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар хот), Багц 1	2025	2025	8,457.1	8,457.1
4.2	Эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар хот), Багц 2	2025	2025	935.9	935.9
5	Ахмад настан, хүүхдийн эмнэлгийн тоног төхөөрөмж (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)	2024	2025	5,000.0	1,500.0
6	"Улаанбаатар театр" ОНӨТҮГ-т шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар хот)	2025	2025	400.0	400.0
7	Онцгой байдлын албанд шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар хот)	2025	2025	992.2	992.2
8	Алсын зайн мэдрэгчтэй угаарын хий модрөгчийг суурилуулах ажил (Улаанбаатар хот)	2025	2025	7,650.0	7,650.0
9	Агро сити дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах	2025	2025	2,332.7	2,332.7
ДҮН				35,143.9	31,643.9



תעודת זהות לרבות  
הנכנסת לרבות



•• תעודת זהות

•• תעודת זהות ••

הנכנסת לרבות •• תעודת זהות ••  
הנכנסת לרבות •• תעודת זהות ••

הנכנסת לרבות •• תעודת זהות ••

הנכנסת לרבות •• תעודת זהות ••  
הנכנסת לרבות •• תעודת זהות ••  
הנכנסת לרבות •• תעודת זהות ••  
הנכנסת לרבות •• תעודת זהות ••  
הנכנסת לרבות •• תעודת זהות ••  
הנכנסת לרבות •• תעודת זהות ••  
הנכנסת לרבות •• תעודת זהות ••  
הנכנסת לרבות •• תעודת זהות ••  
הנכנסת לרבות •• תעודת זהות ••  
הנכנסת לרבות •• תעודת זהות ••